



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2013 оны 57 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. Мэдээлэл, харилцаа холбооны салбар үүсч хөгжсөний 93 жилийн ой, Цахилгаан холбоо, мэдээлэлжсэн нийгмийн Дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан баярын хурал зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажлын удирдамжийг хоёрдугаар, баярыг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Баярын хурлын бэлтгэл ажлыг бүрэн хангасны үндсэн дээр зохион байгуулж, үр дүнг газрын удирдлагад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Алтансүх/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЖАДАМБАА

110939

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын 2014 оны 8 сарын 17 өдрийн
8.4 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УХА0514 5202965

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Алтансүх Тус газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын
ажиллагааны газрын дарга

Нарийн бичгийн дарга:

З.Болормаа Тус газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын
ажиллагааны газрын мэргэжилтэн
Б.Болормаа Тус газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын
ажиллагааны газрын мэргэжилтэн

Гишүүд:

Н.Цэвээндарь Тус газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын
ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн

Т.Наранмандах Харилцаа холбооны зохицуулах хорооны Эрх зүй,
мэдээлэл, захиргааны албаны дарга

О.Мөнгөнсүх Үндэсний дата төв УТҮГ-ын Захиргаа,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Ц.Наранцэцэг Радио, телевизийн сүлжээ УТҮГ-ын Захиргаа, хүний
нөөцийн хэлтсийн дарга

Ц.Эрдэнэлхам Мэдээллийн технологийн үндэсний парк УТҮГ-ын
Захиргаа, хүний нөөцийн газрын дарга

Б.Сайханбаяр МЦХ ХК-ний Захиргаа удирдлагын газрын дарга

Б.Оюунцэцэг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ний Захиргаа
хүний нөөцийн газрын дарга

С.Баасандолгор Монгол шуудан ТӨХК-ний захиргаа, удирдлагын
хэлтсийн дарга

Г.Нэргүй Харилцаа холбоо, дэвшилтэт технологийн ажлын
албаны мэргэжилтэн

Л.Батбаяр МТШХХГ-ын Төрийн захиргааны удирдлага, хамтын
ажиллагааны газрын мэргэжилтэн

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын 2014 оны 03 сарын 17 өдрийн
84 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

УХА0514 5202965

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ


Зорилго: Мэдээлэл, харилцаа холбооны салбар үүсч хөгжсөний 93 жилийн ой, Цахилгаан холбоо, мэдээлэлжсэн нийгмийн Дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх

Хугацаа: 2014 оны 5 дугаар сарын 28

Ажлын хэсэг нь дараах удирдамжийг баримтлан ажиллана. Үүнд:

1. Ойн баярын арга хэмжээний хуралд тавих илтгэлийг боловсруулж бэлэн болгох;
2. Төр засгийн дээд шагналаар шагнуулах хүмүүсийн материалыг бүрдүүлж холбогдох дээд байгууллагуудад хүргүүлэх;
3. Ойн арга хэмжээг зохион байгуулах газрыг товлож, гэрээ байгуулах;
4. Радио телевиз, хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр сурталчилгаа зохион байгуулах;
5. Мэдээлийн технологи, шуудан, харилцаа холбооны салбараас хийсэн ажлын танилцуулга хэвлүүлэх;
6. Баярын хурлын арга хэмжээг зохион явуулсан тайланг газрын удирдлагад танилцуулах.

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын 2014 оны 23 сарын 17 өдрийн
84 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН БАЯРЫГ 5202965
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Хийх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	МХХ-ны салбарын баярыг тэмдэглэх ажлын хэсгийг байгуулж, хуралдуулах	4-р сарын 03	Н.Цэвээндарь Б.Болормаа З.Болормаа
2	Төрийн дээд шагналд салбарын ажилтнуудыг тодорхойлж Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэх	4-р сарын 15	Б.Алтансүх Л.Батбаяр
3	Салбар, харъяа болон бусад байгууллагуудын ажилтнуудад "Мэдээлэл харилцаа холбооны тэргүүний ажилтан" цол, тэмдэг, Хүндэт холбоочин, Жуух бичгээр шагнах ажлыг зохион байгуулах	5-р сарын 25	Б.Алтансүх Л.Батбаяр
4	Радио телевиз, хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр сурталчилгаа зохион байгуулах	5-р сарын 20	Г.Нэргүй
5	МХХ-ны салбарын баярын хурал, концерт	5-р сарын 28	Б.Алтансүх Ажлын хэсэг
6	Шагнал гардуулах ёслолын арга хэмжээний хүлээн авалт	5-р сарын 28	Б.Алтансүх Ажлын хэсэг
7	"Радио Монгол" эрдэм шинжилгээний хурлыг Төрийн ордонд зохион байгуулах	5-р сарын 22	Б.Алтансүх Ажлын хэсэг